



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2014  
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Лавлах зүйл байвал  
70484030 дугаарын  
утаснаас лавлана уу?  
Х.Түвшинбаяр

Тэргүүлэх аудитор  
Өрөөний утас 70483413  
Р.Цанжидмаа  
Аудитын менежер  
өрөөний утас 70484055

Ж.Бүжинханд  
Ахлах аудитор  
өрөөний утас 70484030

Г.Энхдэлгэр

Шинжээч

Хавсралт1: Агуулга

Хавсралт2: Аудитын гэрчилгээ

Хавсралт3: Акт, албан шаардлага,  
менежментийн захидал

Хавсралт4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн аудитын газар

АГУУЛГА

ХУУДАС

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:
4. Дотоод хяналт
5. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
6. Шилэн дансны мэдээлэл
7. Олж тогтоосон гол эрсдэл, үр дагавар
8. Санхүүгийн тайлан, гол онцлог гүйлгээ, түүний талаар тайлбар
9. Аудитаар илэрсэн зөрчлүүд болон тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
10. Залуулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараа жилийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт Материаллаг бус залуулагдаагүй алдааны талаарх тайлбар
14. Аудитын дүгнэлт

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТ	Санхүүгийн тайлан
ЗД	Засаг дарга
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
НД	Нийгмийн даатгал
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

**Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын харьяа орон нутаг дахь Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодоох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт бөгөөд Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 1 дүгээр сарын 07-наас 01 дүгээр сарын 09-ны хооронд хийхээр төлөвлөсөн боловч ҮАГ-аас мөрдөж байгаа СТА-ын журам шинэчлэгдсэн тэй холбоотой төлөвлөгөө, гүйцэтгэлийн олон маягтын дагуу хийж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор өмнөх аудитын хуваарь хойшилсноор 1 сарын 23-наас 01 сарын 27-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

**Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн захирагч нь Монгол улсын "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн санд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 05 дугаар тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр, төслүүд нэмж батлагдсан байна.

**Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны төсвийг улсын төсвөөс олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого зарчмуудыг үнэлж ажил гүйлгээ, үлдэгдлийг бүгдийг анхан шатын баримтаас журнал, тайлан руу хөөн шалгах горимыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн программ нийцсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед "бага" гэж тооцсон ба дахин хянаж үзэхэд дотоод хяналт хариуцсан

орон тооны мэргэжилтэн байдаг бөгөөд тодорхой төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан холбогдох албан тушаалтнаар батлуулан ажилладаг боловч хяналт шалгалтыг хараахан чанартай хийж гүйцэтгэдэггүй, өмнөх жилийн нийцлийн аудит болон жил бүрийн санхүү тайлангийн баталгаажуулах аудитаар гарсан зөрчил давтагдан илэрч байгаа нь дотоод хяналтын үр дүнг сайжруулах шаардлагатай байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

### **Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь ХЭД төв сангаас 819630.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 680000.0 мянган төгрөгөөр санхүүжсэн байна. Мөн ХБИ ажиллуулаагүй байгууллагын ажлын байрны нөхөн төлбөрт нийт 27103.8 мянган төгрөг, 2013 оны жилийн эцсийн үлдэгдэл болох 58371.9 мянган төгрөгийг сангийн яамд төвлөрүүлж авлаагаар тусгасан нь 2014 онд орж ирсэн. Зардлын тухайд нийт 8 хөтөлбөр, 2 төсөл арга хэмжээ, 2 үйлчилгээ зэрэгт 607848.6 мянган төгрөгийг зарцуулж 157627.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

### **Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусгахаар заасан боловч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 оны жилийн төсөв батлагдаагүй учраас үндсэн мэдээллээс бусад төсвийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### **Олж тогтоосон гол эрсдэл, үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Томилолтын хуудас, холбогдох анхан шатны баримтгүйгээр жолооч Ц.Өлзийбаатарт 5 хоногийн томилолт болох 60.0 мянган төгрөгийг илүү олгосон, Малчин өрхийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан малчдын мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, бизнес инкубацийн өрхийн зардлыг 1402.9 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан, Татварын хэлтэст 3888.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн боловч авлагыг тусгаагүй, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг дэмжих арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангаагүй 6 өрхийг малжуулсан, төсвийн тодотгол хийгдээгүй байхад урсгал санхүүжилтыг 139630.0 мянган төгрөгөөр дутуу авсан зэрэг нийт 174980.9 мянган төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайлан, гол онцлог гүйлгээ, түүний талаар тайлбар**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг болон бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг нарийвчилсан горьсон сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт зардал төсөл хөтөлбөрийн 64.8 хувийг тус тус эзэлж байна.

#### **Мөнгөн хөрөнгийн талаар**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь тайлант онд 819630.0 мянган төгрөг батлагдсан боловч 680000.0 мянган төгрөгөөр санхүүжилт авч, ХБИ ажиллуулаагүй байгууллагын ажлын байрны нөхөн төлбөрт нийт 27103.8 мянган төгрөг, урьд оны авалга болох 58371.9 мянган төгрөг орж ирсэн. Зардлын тухайд нийт 8 хөтөлбөр, 2 төсөл арга хэмжээ, 2 үйлчилгээ зэрэгт 607848.6 мянган төгрөгийг зарцуулж 157627.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

#### **Өглөг, авлагын талаар**

Авлагын эхний үлдэгдэл 58371.9 мянган төгрөгийг тайлант онд барагдуулж, шинээр малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малчдаас авах урт хугацаат авлага 100000.0 мянган төгрөг, ХХОАТ-ын авлага 3888.0 мянган төгрөг, нийт 103888.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Харин өглөгийн тухайд оны эхний үлдэгдэлгүй, тайлант хугацаанд өглөг үүсээгүй байна.

#### **Аудитаар илэрсэн зөрчлүүд болон тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн материаллаг түвшинг нийт орлогын 2 хувиар тооцож 14142.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7 дахь заалтыг зөрчин томилолтын хуудас, холбогдох анхан шатны баримтгүйгээр жолооч Ц.Өлзийбаатарт 5 хоногийн томилолт болох 60.0 мянган төгрөгийг илүү олгосон.

Шийдвэрлэлт: Илүү олгосон 60.0 мянган төгрөгийн томилолтыг төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.2.2 дахь заалтыг зөрчин малчин өрхийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан малчдын мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, бизнес инкубацийн өрхийн зардлыг 1402.9 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан.

Шийдвэрлэлт: бизнес инкубацийн үйлчилгээний зардлыг малчдад илүү зарцуулсан 1402.9 мянган төгрөгийг төлүүлж төсвийн орлого болгох

3. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.1 дэх заалтыг зөрчин малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг дэмжих арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангаагүй 6 өрхийг малжуулсан.

Шийдвэрлэлт: 1.Эдгээр өрхийн малыг буцаан авч шаардлага хангахуйц өрхтэй гэрээ хийн шилжүүлэн өгөх

- 2. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргасан, өөрийн хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсан дотоод хяналтын мэргэжилтэн Б.Баярмаа, ахлах мэргэжилтэн Н.Баярсайхан нарт хуулийн дагуу хариуцлага тооцох
- 4. Төсвийн тухай хуулийн 14.2.2, 14.2.3 дахь заалтыг зөрчин төсвийн тодотгол хийгдээгүй байхад урсгал санхүүжилтыг 139630.0 мянган төгрөгөөр дутуу авсан

Шийдвэрлэлт: Хэрэгжүүлэх хөтөлбөрт үндэслэн санхүүжилтийг бодитой тодорхойлж, төсвийг үр ашигтай удирдан, гүйцэтгэлийг хангаж ажиллах

**Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:**

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг зөрчин санхүүгийн тайланд татварын хэлтэст 3888.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн боловч авлагыг тусгаагүй.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд тусгаагүй авлагыг залруулсан.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитаар нийт 174980.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3888.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулсан ба 1462.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 30000.0 мянган төгрөгөнд зөрчил арилгуулах албан шаардлага, 139630.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидал илгээлээ. Санхүүгийн тайланд нөлөөлж болохуйц материаллаг 31462.9 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр байгууллагуудын удирдлага анхаарлаа хандуулж шийдвэрлэх шаардлагатай /авч үзсэн түүврийн хэмжээнд/. Тухайлбал:

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолыг үндэслэн төсөл хөтөлбөрт хамрагдах шаардлагыг хангасан аж ахуй нэгж, иргэнийг хамруулах
- Санхүүгийн дэмжлэг авахыг хүссэн иргэдээс ирсэн үнэн зөв, бүрэн гүйцэд материалд үндэслэн дэмжлэгийг олгох, дэмжлэг авсан иргэдийн ажлын тайланг шаардлага хангахуйц байдлаар авах.
- Шилэн дансны цахим хуудсанд 2015 оны төсөв, бусад мэдээллээ байршуулах
- Дотоод хяналтын үйл ажиллагааг үр дүнтэй, хариуцлагатай болгох

**Дараа жилийн аудитаар авч үзэх асуудлууд**

Авч үзсэн түүврийн хэмжээнд үндэслэн дүгнэн хэлэхэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь зарим нэг зүйл алдаа дутагдалтай байна. Тухайлбал дараа жилийн аудитаар нэн түрүүнд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, мөн дотоод хяналтыг үзэх шаардлагатай гэж үзэж байна.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх жилд хийсэн нийцлийн аудитаар өгсөн нийт 84968.7 мянган төгрөгийн актаас 38693.2 мянган төгрөг нь цуцлагдаж, ХБИ-ийг ажиллуулаагүйн төлбөрт 27103.8 мянган төгрөгийг авч, 4109.7 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгож, одоогоор 15062.0 мянган төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Албан шаардлагын хувьд хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн биелэлтийг ханган ажиллах албан шаардлага авсан боловч бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдах шаардлага хангасан, бичиг баримтын зөрчилгүй иргэдийг байхаар зохион байгуулах албан шаардлага авсан ба албан шаардлагын хэрэгжилтийг сайн хангаж ажилласан байна. Сургалтанд хамрагдсан иргэдийн хоол унааны зардлыг журмын дагуу олгож байхаар албан шаардлага авсан ба



үүний дагуу Хөдөлмөрийн сайдын 2014 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/27 дугаар тушаалын дагуу бодож олгосон байна.

**ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ**

Дээр дурьдсан алдаа зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөхийг санал болгож байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, төлбөр зөрчлийн жагсаалт 1 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ ЗӨВШӨӨРСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВЦИНБАЯР

**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

Р.ЦАНЖИДМАА

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

Ж. БУЖИНХАНД

ШИНЖЭЭЧ

Г.ЭНХДЭЛГЭР

2015.01.27



ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Р.ПҮРЭВДОРЖ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

82091 Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, Баянхайрхан баг,  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2015.07.09 № 42  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хязгаарлалттай санал дүгнэлт

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, 15.2-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газраас аудит хийв.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн тайланд аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Санхүүгийн тайлангийн зөрчилтэй илэрхийлсэн эсвэл орхигдуулсан мэдээллийн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нарын шийдвэрт нөлөөлөх материаллаг чанарын түвшинг 14142.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

Томилолтын хуудас, холбогдох анхан шатны баримтгүйгээр жолооч Ц.Өлзийбаатарт 5 хоногийн томилолт болох 60.0 мянган төгрөгийг илүү олгосон, Малчин өрхийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан малчдын мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, бизнес инкубацийн өрхийн зардлыг 1402.9 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан,

ГАА-2015/54/-СТА-ТШЗ

000111

Татварын хэлтэст 3888.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн боловч авлагыг тусгаагүй, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг дэмжих арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангаагүй 6 өрхийг малжуулсан зэрэг нийт 35350.9 мянган төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 3888.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, залруулагдах боломжгүй 31462.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

#### **Хязгаарлалттай санал дүгнэлт**

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

Төлбөр зөрчлийн жагсаалт

№	Зөрчлийн		Шийдвэрийн		Нийт зөрчлийн мөнгөн дүн	Загруулга	Шийдвэр						үр өгөөж болох			
	Зөрчлийн утга	Зөрчсөн хуулийн заалт	Хариуцах эзэн	Заалт			Акт			Албан шаардлага		Зөвлөмж		Санхүү	Санхуу/бус	
							Улсын төсвийн орлого	Орон нутгийн орлого	байгууллага	Зөрчил арилгах	Заалт	Хариуцлага тооцох	Мөнгөн дүн			заалт
<b>Зөрчлийн нийт дүн</b>					174,980.9	3,888.0	-	1,462.9	-	30,000.0	1.0	1.0	139,630.0	-	1,462.9	-
1	Томилолтын хуудас, холбогдох анхан шатны баримтгүйгээр жолооч Ц.Өлзийбаатарт 5 хоногийн томилолт болох 60.0 мянган төгрөгийг илүү олгосон.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7 /Анхан шатны баримтгүй ажил гүйцээж бүртгэл тайланд тусгахыг хориглоно/	Дарга: Р.Пүрэвдорж, Нягтлан бодогч: Л.Удвал		60.0			60.00							60	
2	Малчин өрхийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан малчдын мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, бизнес инкубацийн өрхийн зардлыг 1402.9 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хэсрэлтын 3.2.2 /ХЭДС-аас малчин өрхийн төсөлд хуваарилсан хөрөнгийн 80 хувийг сайн үүлдрийн, өндөр ашиг шимтэй малаар малжуулахад, 20 хувийг мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, нийтийн хамарсан ажил, жижиг зээл, зээлийн хүүгийн нөхөн төлбөр, бизнес инкубацийн бусад зардалд зарцуулна/	Дарга: Р.Пүрэвдорж, Нягтлан бодогч: Л.Удвал, Хариуцсан мэргэжилтэн	Илүү олгосон 60.0 мянган төгрөгийн томилолт, бизнес инкубацийн үйлчилгээний зардлыг малчдад илүү зарцуулсан 1402.9 мянган төгрөг нийт 1462.9 мянган төгрөгийг төлүүлж төсвийн орлого болох	1,402.9		1,402.9								1,402.9	
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг дэмжих арга хэмжээнд төвшгөдөх шаардлагыг хангаагүй 6 өрхийг малжуулсан	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хэсрэлтын 3.1 /Хөтөлбөрт дор дурдсан шаардлага хангасан малчинг хамруулна/	Дарга: Р.Пүрэвдорж, Нягтлан бодогч: Л.Удвал, Хариуцсан мэргэжилтэн	1.Эдгээр өрхийн малыг буцаан авч шаардлага хангахгүйг өрхтэй гэрээ хийн шилжүүлэн өгөх 2.Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргасан, өөрийн хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсан дотоод хяналтын мэргэжилтэн Б.Баярмаа, ахлах мэргэжилтэн Н.Баярсайхан нарт хуулийн дагуу хариуцлага тооцох	30,000.0				30,000.0	1	1					
4	Татварын хэлтэст 3888.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн боловч авлагыг тусгаагүй.	Төсвийн тухай хуулийн 6.4.8 /Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсэхгүй байх/	Дарга: Р.Пүрэвдорж, Нягтлан бодогч: Л.Удвал	Аудитын явцад залруулав	3,888.0	3,888.00										
5	Төсвийн тодотгол хийгдээгүй байхад урсгал санхүүжилтыг 139630.0 мянган төгрөгөөр дутуу авсан	Төсвийн тухай хуулийн 14.2.2 / төсвийн ерөнхийлөн удирдагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох/ 14.2.3 /төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах/	Дарга: Р.Пүрэвдорж, Нягтлан бодогч: Л.Удвал	Хэрэгжүүлэх хөтөлбөрт үндэслэн санхүүжилтийг бодитой тодорхойлж, төсвийг үр ашигтай удирдан, гүйцэтгэлийг хангаж ажиллах	139,630.0								139630			

Зөвшөөрсөн:  
Дарга: Р.Пүрэвдорж  
Нягтлан бодогч: Л.Удвал

Анхан шатны хяналт хийсэн  
Бэлтгэсэн

Ахлах аудитор  
Шинэсэч  
Ж.Бүжинханд  
Г.Энхтүвшин





ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Р.ПҮРЭВДОРЖ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

82091 Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, Баянхайрхан баг,  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2015.02.09

№

01/32

Төсвийн орлого болгох тухай

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Томилолтын хуудас, холбогдох анхан шатны баримтгүйгээр жолооч Ц.Өлзийбаатарт 5 хоногийн томилолт болох 60.0 мянган төгрөгийг илүү олгосон.
- ❖ Малчин өрхийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан малчдын мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, бизнес инкубацийн өрхийн зардлыг өрх тус бүрээр тооцож үзэхэд нийт 1402.9 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан.

**Энэ нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7 /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно/, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.2.2 /ХЭДС-аас малчин өрхийн төсөлд хуваарилсан хөрөнгийн 80 хувийг сайн үүлдрийн, өндөр ашиг шимтэй малаар малжуулахад, 20 хувийг мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, нийтийг хамарсан ажил, жижиг зээл, зээлийн хүүгийн нөхөн төлбөр, бизнес инкубацийн бусад зардалд зарцуулна/ гэсэн заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.


Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т / улсад болон байгууллагад хохирол учруулсан"-д төлбөрийн акт тогтооно/ гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

000065

1. Илүү олгосон 60.0 мянган төгрөгийн томилолт, бизнес инкубацийн үйлчилгээний зардлыг малчдад илүү зарцуулсан 1402.9 мянган төгрөг нийт 1462.9 мянган төгрөгийг төлүүлж 2015 оны 05 сарын 15-ны дотор аймгийн төрийн сангийн татварын бус орлогын 05000982 тоот дансанд оруулах
2. Дээрх төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2015 оны 5 дугаар сарын 20-ны дотор Говь-Алтай аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөрийн хэлтсийн дарга Р.Пүрэвдорж, нягтлан бодогч Л.Удвал нарт үүрэг болгов.
3. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн 2.2 дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцох болно.
4. Шийдвэрийг эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор дээд албан тушаатанд гомдол гаргах эрхтэй.

## АКТЫГ

### ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын харъяа  
Говь-Алтай аймгийн Аудитын газрын  
Ахлах аудитор:  Ж.Бүжинханд



### ЗӨВШӨӨРСӨН:

Хөдөлмөрийн хэлтсийн  
Дарга:  Р.Пүрэвдорж  
Нягтлан бодогч:  Л.Удвал





Илүү олгосон томилолтын тооцоо

2015.01.27

	сар	хэн	хаашаа	он сар	хоног	нийт тооцон хоног	томил олто олгосон хоног	зөрүү	дуудсан бичиг байгаа эсэх	томилотын хуудас	олгосон томилолт	илүү олгосон томилолт
Х/21-нд олгосон томилолт	9	пүрэвдорж	тайшир гуули	9/23-9/28	5	5	5	0	+	+	90000	
	9	энхтайван	тайшир гуули	9/23-9/28	5	11	11	0	+	+	198000	
	9	энхтайван	шарга төгрөг	9/10-9/16	6			0	+	+		
	9	удвал	тайшир гуули	9/23-9/28	5	11	11	0	+	+	132000	
	9	удвал	шарга төгрөг	9/10-9/16	6			0	+	+		
	9	баярмаа	шарга төгрөг	9/10-9/16	6	11	11	0	+	+	198000	
	9	баярмаа	тайшир гуули	9/23-9/28	5			0	+	+		
	9	Өлзийбаатар	шарга төгрөг	9/10-9/16	6	6	11	-5	байхгүй	байхгүй	132000	60000

Зөвшөөрсөн:

Нягтлан бодогч:

*Урвал*


Л.Удвал

Хянасан:

Ахлах аудитор:

Бэлтгэсэн:

Шинжээч:



Ж.Бүжинханд

Г.Энхдэлгэр





ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Р.ПҮРЭВДОРЖ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

82091 Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, Баянхайрхан баг,  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2015.02.09.

№

01/27

Зөрчил арилгах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг дэмжих арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангаагүй 6 өрхийг 30000.0 мянган төгрөгөөр малжуулсан зөрчил илэрлээ.

**Энэ нь:** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.1 /Хөтөлбөрт дор дурдсан шаардлага хангасан малчинг хамруулна/ дахь заалтыг зөрчсөн байна.


“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн Шаардах нь:

1. Эдгээр өрхийн малыг буцаан авч шаардлага хангахуйц өрхтэй гэрээ хийн, шилжүүлэн өгөх ажлыг зохион байгуул.
2. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргасан, өөрийн хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсан дотоод хяналтын мэргэжилтэн Б.Баярмаа, ахлах мэргэжилтэн Н.Баярсайхан нарт хуулийн дагуу хариуцлага тооц.

Албан шаардлагын биелэлтийг 2015 оны 5 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөрийн хэлтсийн дарга Р.Пүрэвдорж, нягтлан бодогч Л.Удвал нарт үүрэг болгож байна.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн 2.2 дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцох болно.

АХЛАХ АУДИТОР



Ж.БҮЖИНХАНД

000065

**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2014.12.31

БАЛАНСЫН ЗҮЙЛ		АУДИТЛАГДСАН	
		Эхний	Эцсийн
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>			
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
310101	Жижиг мөнгөн сан		
310201	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	-
310202	Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/		
310204	Богино хугацаат хадгаламж		
310203	Замд яваа мөнгөн хөрөнгө		
<b>АВЛАГА</b>		<b>408,371,939.01</b>	<b>453,888,000.00</b>
3301	Байгууллагаас авах авлага		3,888,000.00
3302	Жижиг зээл	350,000,000.00	350,000,000.00
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		100,000,000.00
	Төрийн сан	58,371,939.01	
<b>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</b>			
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>408,371,939.01</b>	<b>453,888,000.00</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>			
	Биет хөрөнгө	-	-
39020101	Барилга, байгууламж		
39020102	Хуримтлагдсан элэгдэл		
39020201	Авто-тээврийн хэрэгсэл		
39020202	Хуримтлагдсан элэгдэл		
39020301	Машин тоног төхөөрөмж		
39020302	Хуримтлагдсан элэгдэл		
39020401	Тавилга, аж ахуйн эд хогшил		
39020402	Хуримтлагдсан элэгдэл		
390207	Түүх, соёлын дурсгалт зүйлс		
39020801	Бусад үндсэн хөрөнгө		
39020802	Хуримтлагдсан элэгдэл		
39020803	Номын фонд		
390209	Дуусаагүй барилга		
	Биет бус хөрөнгө		-
39030101	Програм хангамж		
39030102	Хуримтлагдсан элэгдэл		
39030201	Бусад биет бус хөрөнгө		
39030202	Хуримтлагдсан элэгдэл		
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>			
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>408,371,939.01</b>	<b>453,888,000.00</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
4103	Өгөлгө		
41030101	Цалин		
41030102	НДШ		
41030103	ХАОАТ		
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>			
42	Урт хугацаат өр төлбөр		
<b>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</b>			
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>			
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ</b>			
510302	Хуримтлагдсан үр дүн		
510301	Өмнөх үеийн үр дүн	85,567,801.01	408,371,939.01
510302	Тайлант үеийн үр дүн	322,804,138.00	45,516,060.99
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>		<b>408,371,939.01</b>	<b>453,888,000.00</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>		<b>408,371,939.01</b>	<b>453,888,000.00</b>

Бэлтгэсэн  
Шинжээч  
Анхан шатанд хянасан  
Ахлах аудитор  
Хоёр дахь шатанд хянасан  
Аудитын менежер  
Хүлээн зөвшөөрсөн  
Нягтлан бодогч



АУДИТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2014.12.31

Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
<b>Татаас санхүүжилтийн орлого</b>	<b>2,058,715,460.00</b>	<b>707,103,760.00</b>
ХЭД төв сангаас хуваарилсан хөрөнгө	2,049,029,100.00	680,000,000.00
ХЭД төв сангийн чөлөөт үлдээдлийг банкинд байршуулсны	0.00	0.00
Гад иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажлын байрны төлбөр	0.00	0.00
ХЭД үйл ажиллагааны орлого	8,760,000.00	0.00
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр	126,360.00	27,103,760.00
Бусад	800,000.00	0.00
<b>САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,058,715,460.00</b>	<b>707,103,760.00</b>
<b>Сангийн үйл ажиллагааны зардал</b>		
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	14,667,330.00	10,223,170.00
Ажилд зуучлах	800,820.00	2,904,000.00
Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ	98,179,100.00	40,838,000.00
Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		51,425,000.00
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	229,946,658.00	87,288,890.00
Эзэнтэй Монгол хөтөлбөр	114,820,314.00	116,189,922.00
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмж		30,720,000.00
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		61,272,000.00
40-с дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөт		32,232,432.00
Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл		24,979,998.00
Ажилтнуудын чаваахи бэхжүүлэх		5,918,600.00
Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр		
ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөдөлмөрийн са	126,026,600.00	6,988,400.00
ХЭД үйл ажиллагааг хэрэгжүүлэгч ажилтнуудын чадаахи бэ	16,470,500.00	31,664,130.00
Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хө		1,316,000.00
Сум хөгжүүлэх сан	1,135,000,000.00	
Төсөөт төвлөрүүлсэн хөрөнгө		157,627,157.01
<b>САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>1,735,911,322.00</b>	<b>661,587,699.01</b>
<b>САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>322,804,138.00</b>	<b>45,516,060.99</b>

Бэлтгэсэн

Шинжээч

Анхан шатанд хянасан

Ахлах аудитор

Хоёр дахь шатанд хянасан

Аудитын менежер

Хүлээн зөвшөөрсөн


Нягтлан бодогч

Г.Энхдэлгэр

Ж.Бүжинханд

Р.Цэнжидмаа

Л.Удвал



АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2014.12.31

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Татаас санхүүжилтийн орлого</b>		
ХЭД төв сангаас хуваарилсан хөрөнгө	2,049,029,100	680,000,000
ХЭД төв сангийн чөлөөт үлдээгдлийг банкинд байршуулсны хүү		
Бусад орлого	90,811,001	-
ХЭД үйл ажиллагааны орлого	9,233,500	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр	126,360	27,103,760
Төрийн сан		58,371,939
<b>САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,149,199,961</b>	<b>765,475,699</b>
<b>Сангийн үйл ажиллагааны зардал</b>		
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	14,897,730	10,223,170
Ажилд зуучлах	800,820	2,904,000
Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ	102,391,900	40,838,000
Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		51,425,000
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	230,420,158	187,288,890
Эзэнтэй Монгол хөтөлбөр	114,820,314	116,189,922
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих		30,720,000
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		65,160,000
40-с дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		32,232,432
Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл		24,979,998
Ажилтнуудын чадавхи бэхжүүлэх		5,918,600
Сум хөгжүүлэх сан	1,135,000,000	-
ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөдөлмөрийн сайд	126,026,600	6,988,400
ХЭД үйл ажиллагааг хэрэгжүүлэгч ажилтнуудын чадавхи бэхж	16,470,500	31,664,130
Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөл		1,316,000
Жижиг зээл олгох	350,000,000	-
Төсвөт төвлөрүүлсэн хөрөнгө	58,371,939	157,627,157
<b>САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>2,149,199,961</b>	<b>765,475,699</b>
<b>САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Зөрүү		

Бэлтгэсэн  
Шинжээн  
Анхан шатанд хянасан  
Ахлах аудитор  
Хоёр дахь шатанд хянасан  
Аудитын менежер  
Хүлээн зөвшөөрсөн  
Нягтлан бодогч

Г Энхдэлгэр  
Ж Бүжинханд  
Р Цанжидмаа  
П Удвал

**АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2014.12.31

	Үзүүлэлт	Засварын газрын	Дахин үнэлгээний	Хуримтлагдсан үр дүн	Засварын газрын хувь оролцооны
8	<b>2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>408,371,939.01</b>	<b>408,371,939.01</b>
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>408,371,939.01</b>	<b>408,371,939.01</b>
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
14	Тайлант үеийн үр дүн			45,516,060.99	45,516,060.99
15	<b>2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>453,888,000.00</b>	<b>453,888,000.00</b>

**Бэлтгэсэн**

Шинжээч

**Анхан шатанд хянасан**

Ахлах аудитор

**Хоёр дахь шатанд хянасан**

Аудитын менежер

**Хүлээн зөвшөөрсөн**

Нягтлан бодогч



## Төсвийн гүйцэтгэлийн тохиргоо, гүйцэтгэлийн тайлан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2014.12.31

Үзүүлэлт	Цэвэр төсөв	Гүйцэтгэл		Тохируулга	Цэвэр гүйцэтгэл	
		Зардал	Орлого		Зардал	Орлого
<b>Сангийн үйл ажиллагааны зардал</b>	<b>819,630,000.00</b>	<b>765,475,698.98</b>		<b>157,627,157.01</b>	<b>607,848,541.97</b>	
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	10,000,000.00	10,223,170.00			10,223,170.00	
Ажилд зуучлах	4,000,000.00	2,904,000.00			2,904,000.00	
Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ	134,000,000.00	40,838,000.00			40,838,000.00	
Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	59,350,000.00	51,425,000.00			51,425,000.00	
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	210,000,000.00	187,288,890.00			187,288,890.00	
Эзэнтэй Монгол хөтөлбөр	120,100,000.00	116,189,921.97			116,189,921.97	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	38,060,000.00	30,720,000.00			30,720,000.00	
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	126,000,000.00	65,160,000.00			65,160,000.00	
40-с дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	34,000,000.00	32,232,432.00			32,232,432.00	
Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	35,000,000.00	24,979,998.00			24,979,998.00	
Ажилтнуудын чаваахи бэхжүүлэх	6,120,000.00	5,918,600.00			5,918,600.00	
Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр	-	-			-	
ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	7,000,000.00	6,988,400.00			6,988,400.00	
ХЭД үйл ажиллагааг хэрэгжүүлэгч ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	34,500,000.00	31,664,130.00			31,664,130.00	
Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдэл	1,500,000.00	1,316,000.00			1,316,000.00	
Жижиг зээл олгох	-	-			-	
Төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө	-	157,627,157.01		157,627,157.01	-	
<b>Татаас санхүүжилтийн орлого</b>	<b>819,630,000.00</b>	<b>58,371,939.00</b>	<b>765,475,699.00</b>	<b>157,627,157.01</b>	<b>-</b>	<b>607,848,541.99</b>
ХЭД төв сангаас хуваарилсан хөрөнгө	819,630,000.00		680,000,000.00	72,151,458.01		607,848,541.99
ХЭД төв сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд байрлуулах	-	-	58,371,939.00	58,371,939.00		-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулаагүйн төлбөр	-	-				-
ХЭД үйл ажиллагааны орлого	-	-				-
Ажлын байрны төлбөр	-		27,103,760.00	27,103,760.00		-

Бэлтгэсэн

Шинжээч

Ахлах аудитор

Аудитын менежер

Нягтлан бодогч

Г.Энхдэлгэр

Ж.Бүжигдханд

Р.Цанжидмаа

Л.Удвал

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2014.12.31

Үзүүлэлт	Цэвэр төсөв	Цэвэр гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+ хэтрэлт-	Хувь %
<b>Сангийн үйл ажиллагааны зардал</b>	<b>819,630,000</b>	<b>707,103,760</b>	<b>112,526,240</b>	<b>86%</b>
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	10,000,000	10,223,170	(223,170)	102%
Ажилд зуучлах	4,000,000	2,904,000	1,096,000	73%
Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ	134,000,000	40,838,000	93,162,000	30%
Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	59,350,000	51,425,000	7,925,000	87%
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	210,000,000	187,288,890	22,711,110	89%
Эзэнтэй Монгол хөтөлбөр	120,100,000	116,189,922	3,910,078	97%
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	38,060,000	30,720,000	7,340,000	81%
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	126,000,000	65,160,000	60,840,000	52%
40-с дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	34,000,000	32,232,432	1,767,568	95%
Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	35,000,000	24,979,998	10,020,002	71%
Ажилтнуудын чаваахи бэхжүүлэх	6,120,000	5,918,600	201,400	97%
Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр	-	-	-	-
ЗГ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөдөлмөрийн сайды	7,000,000	6,988,400	11,600	100%
ХЭД үйл ажиллагааг хэрэгжүүлэгч ажилтнуудын чадаахи бэхжүүлэх	34,500,000	31,664,130	2,835,870	92%
Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ	1,500,000	1,316,000	184,000	88%
Жижиг зээл олгох	-	-	-	-
Төсөөт төвлөрүүлсэн хөрөнгө	-	99,255,218	(99,255,218)	-
<b>Татаас санхүүжилтийн орлого</b>	<b>819,630,000</b>	<b>707,103,760</b>	<b>112,526,240</b>	<b>86%</b>
ХЭД төв сангаас хуваарилсан хөрөнгө	819,630,000	680,000,000	139,630,000	83%
ХЭД төв сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулсны хүчин зүйлс	-	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр	-	-	-	-
ХЭД үйл ажиллагааны орлого	-	-	-	-
Ажлын байрны төлбөр	-	27,103,760	(27,103,760)	-
Бусад орлого	-	-	-	-

Бэлтгэсэн  
Шинжээч  
Анхан шатанд хянасан  
Ахлах аудитор  
Хоёр дахь шатанд хянасан  
Аудитын менежер  
Хүлээн зөвшөөрсөн  
Нягтлан бодогч

Г.Энхдүлгэр

Ж.Бүжинханд

Р.Цанжидмаа

Л.Удаал

ЦЮА 008 118301